

тал иймэрхүү аялал зохиогоогүй юмдаг.

Би дээр дурдсан 4 ЭСЯ-нд нийт 5 удаа ажиллахдаа 9 элчин сайдын нүүр үзэж, Лаоссоос ирээд ГЯД-ны ДБУААГ-ын газар, архивт ажиллаж байгаад 1986 оны 10 дугаар сард тэтгэвэрт гарсан юм.

Эх орондоо цэрэгт явж үзээгүй намайг ийм дайн, самуунтай орнуудад ажиллуулсан тэсвэр, хатуужилд сурган хүмүүжүүлж, ийнхүү дурсамж бичихэд хүргэсэн ГЯД-ны хамт олондоо баярлаж байна.

Б.Буд

Тэргүү шаглар

ГАДААД ХАРИЛЦААНД 32 ЖИЛ

Чадах чинээгээр улсад алба хаших нь миний үүрэг гэж бодож явсан. Нам, улс, олон нийтийн байгууллагад 40 гаруй жил ажилласны 32 жилд нь Монгол Улсын Гадаад харилцааны төв болон хилийн чанад дахь байгууллагад алба хашиж, Анх би дипломат алба хашина гэж бодож байсангүй. Учир нь энэ ажилд шаардагдах зохих боловсрол, мэргэжил надад байгаагүй. Тохиролдож байсан хөтгэй явдал, өдрийн тэмдэглэл аятай юмаа дор өгүүлэх зүйлд нурушиж бичье гэж бодсоогүй.

Монгол Улсын гадаад харилцааны байгууллагад миний алба хашсан үе (1960-1992 он) Монгол Улс гадаад бодлого, харилцаандаа тухайн үед баримталж ирсэн онол, зарчимтай холбоотойг хэн бүхэн ойлгох учир нуруших хэрэггүй биз.

1960 оны 7 дугаар сард намайг Монгол Улсын гадаад харилцааны хилийн чанад дахь байгууллагад ажиллуулах шийдвэр гарч ийнхүү дипломат гэдэг нэр хүндтэй, өндөр хариуцлага бүхий албанд шилжсэнээ оршил болгоё.

Дипломат атташегаас элчин сайд хүртэл албан тушаалд 5 удаагийн томилолтоор 13 жил хатас гадаад улсуудад ажилласан маань дипломат албанд суралцах амьдралын их сургууль байлаа.

Африкийн баруун эрэгт орших Гвиней улсад Монгол Улсын ЭСЯ анх 1960 оны 8 дугаар сарын эхээр байгуулагдаж түүнд атташегаар ажиллах үүрэг ногдсон. Прагаас Конакри хүрэх 19 цагийн нислэгийн замд францаар 10 хүртэл тоо, 5 үг цээжилж очсон билээ. Төвд бэлтгэл хийгээгүй, харин газар дээрээ очоод дипломат баримт бичиг боловсруулах, хэлэлцээ, яриа хийх, ёс горимд суралцах ажил эхэлсэн. Энэ бүхэнд манай гадаад харилцааны боловсрол, дадлага бүхий дипломат агсан П.Цэрэнцоодол цаг ямагт тусалж, зааж хэлж өгдөг байсан.

Тэнд хоёр жил ажиллахдаа ямагт халуун дулаан байдаг улс орон, хар арьстны талаар анхны мэдэгдэхүүн авсан. 60-аад он бол колонийн систем задран унаж, Ази, Африк, Латин Америкийн олон орон эрх чөлөө, тусгаар тогтнолоо олж шинэ шинэ улсууд буй болж байсан үе. Харин би колоничлол гэдгийг сонссоноос биш нүдээр үзээгүй байв.

Колонийн дарлал мөлжлөгт олон арав, зуун жилээр нухлагдсан улс, ард түмэн түүний уршгийг хэдхэн жилд аригладаг зүйл биш юм даа гэдгийг мэдэрсэн. Хүн ардын нь амьдрал дорой, боловсрол бага, улсын эдийн засгийн хоцрогдол зэрэг олон зүйлийг нүдээрээ харсны хувьд багттай хэлж байна. Эрх чөлөө, тусгаар тогтнолоо олж авсандаа туйлаас баяртай байгаа хүн ардыг нь ч харсан.

Африкийн улс орон ард түмэн тэр үед Монгол Улсыг мэдэхгүй байсан гэж хэлэхэд ташаа болохгүй байх. Монгол Улсын хувьд гэвэл африкийн ард түмний тусгаар тогтнолыг нь дэмжих, найрсаг харилцаатай байхыг эрмэлзэж дипломат харилцаа тогтоож эхэлсэн. Монгол Улсын хувьд ч тэдний дэмжлэг чухал байсан нь ойлгомжтой.

Гвинейн Ерөнхийлөгч Секу Туре 1960 оны 8 дугаар сард Монголд албан ёсны айлчлал хийсэн нь Африк тивийн улсуудын дотроос Монголд айлчилсан анхны элч төлөөлөгч юм.

1960 оны сүүлчээр Мали улсын Ерөнхийлөгч Модибо Кейта Гвинейд айлчлах үед манай түр хамаарагч П.Цэрэнцоодол түүнтэй уулзаж, хоёр улсын хооронд дипломат харилцаа тогтоохоор ярилцсаныг тодорхой санаж байна. Тэр өдөр түр хамаарагч маань Гвинейн Ерөнхийлөгч Секу Туре, Малийн Ерөнхийлөгч Модибо Кейта хоёрын дунд суугаад тэдэнтэй ярилцаж байгааг нь харахад бахтай байж билээ.

1980-аад оны эхээр Секу Туре Францад айлчлах үед болсон нэгэн хүлээн авалт дээр түүнтэй уулзах завшаан надад тохиосон. Тэр Монголд айлчилснаа дурсаж байдаг гэж яриада монголын ард түмэнд сайн сайхныг ерөөж байсныг энэ ялдамд тэмдэглэе.

Элчин сайдын Яам байгуулахад хогийн шүүр, хувин савнаас эхлээд газар, орон сууц, унаа хүртэл юм юм л хэрэгтэй юм даа гэдгийг Конжарид ЭСЯ байгуулахад оролцсон учир мэдэх болсон. Энэ албанд шинээр ажиллаж байсан надад мэдэхгүйн бэрхшээл их тохиолдож байснаа дурдъя. Хамгийн бэрх зүйл гэвэл, халуун оронд байдаг өвчнөөс сэргийлэх явдал. Энэ талаар манай улс ч, тэнд ажиллахаар анх очсон бидэнд ч туршлага байсангүй. Тийм өвчний нэг-малеригаар өвчилсний уршаар биднээс хэд хэд маань сүүлд өөд болсныг харамсаж дурдъя.

Балканы хойгийн зарим орон-Болгар, Румынд ажиллах завшаан надад тохиолдсон. 1967 онд Москвад дипломатын академи дүүргэж Болгар, дараа нь Румынд суугаа ЭСЯ-дад нарийн бичгийн даргаар ажилласан билээ.

Эдгээр улсуудтай найрсат хамтын ажиллагаа хөгжүүлэх төр, засгийн чиг бодлогыг хэрэгжүүлэхэд эвсэг хамт олонтойгоо хүчин зүтгэж, хийх ёстой зүйлээ зохих ёсоор гүйцэтгэсэн.

Балканы хойгийн улс орнууд нийгмийн байгууламжийн хувьд ч, гадаад бодлого, хөгжлийн хувьд ч янз бүр байлаа. Үүнийг судлахгүйгээр тэр бүс нутгийн байдлыг ойлгох боломжгүй.

Балканыг цөмийн зэвсэггүй бүс болгох, Б.Титогийн дэвшүүлсэн энх тайвнаар "идэвхтэй" зэрэгцэн орших бодлого, Румыны бие даасан бодлого гэх зэрэг олон үзэл баримтлал байж билээ. Болгарын хүн амыг 10 саяд хүргэх гэсэн Г.Димитровын саналыг хэрэгжүүлэх Болгарын бодлого, энэ бүс нутгийн улсуудын хооронд хүн ам, газар нутгийн асуудлаар гарч байгаа маргаан зэрэг нь бидний анхаарлыг зүй ёсоор татсан юм. Дээрх улсуудын аль алинд нь нэг хүний тахин шүтэх явдал улам гүнзгийрэх хандлага ажиглагдсан. Манай улс нэг хүнийг тахин шүтэхийн уршгийг амссан болохоор эдгээр улсуудад хэзээ нэгэн цагт тийм явдал тохиолдож магадгүй юм гэсэн бодол төрж байснаа мартаггүй.

1978 оны 10 дугаар сараас Баруун Европын хэд хэдэн улс-Бельги, Франц, Швейцари, Люксембург, Испани, Португалид суух элчин сайдаар томилогдож 5 жил хагас ажилласан маань миний хувьд дипломатын их сургуульд амьдрал дээр суралцсан гуравдахь дамжаа гэж хэлж болно.

Францад бүгд найрамдахчуудын намын удирдагч Жискар д. Эстен Ерөнхийлөгч байсан суугийн жилүүд, социалистуудын тэргүүн Франсуа Миттеран Ерөнхийлөгч болсон эхний жилүүдэд ажиллав. Бие даасан бодлого явуулдаг их гүрэн-Франц дэлхийн бодлогод зохих байр сууриа эзэлдгийг хэлэх юун.

Монгол, Францын харилцаа 80-аад оны эхээр, юуны өмнө худалдаа, соёлын салбарт ахих хандлага гарсан. Парламентын төлөөлөгчид ч харилцан айлчлав. Хоёр орны харилцаа, ялангуяа худалдаа, эдийн засгийн харилцаа хөгжүүлэх боломжийг судлахаар Францын ГЯД-ны Департаментын захирал тэргүүтэй төлөөлөгчид (парламентын депутатууд, худалдаа, үйлдвэрийн зээд оролцсон) Монголд айлчлахаар бэлтгэж байв. Интра-агра, Томсон зэрэг Францын зарим томоохон пуусууд ч харилцаа хөгжүүлэх тодорхой санал тавьсан. Энэ бүхэнд манай тал нааштай хандаагүй.

Францын ГЯД-ны төлөөлөгчид ирэхээр товлосон хугацаанд "зоочид буудал байхгүй байна" гээд хойшлуулах хариу өгсөн. Эцсийн эцэст Францын тал төлөөлөгчдийнхөө түвшинг бууруулж, Монголд элчин сайд байсан Перрушийг ирүүлсэн. Тэр нь хэлэлцээ хийхэд бус манай зарим удирдлагатай ёслолын чанартай уулзалт хийж урьд байснаа дурсах төдийгөөр хязгаарлах зорилготой байв.

"Интра-агра" пуустай худалдаа хийх асуудлаар манай Гадаад худалдааны Яамны ажилтан Эрдэнэгарьд гэгч Парист очиж уг пуусийнхэнтэй 5 минут уулзаад "худалдааны асуудал мэддэггүй юм байна" гэж "толж" хэлэлцээ хийгээгүй. Энэ мэт хандлага харилцаанд сайн нөлөө үзүүлээгүй.

Францын ЭСЯ "Улаанбаатар" зоочид буудалд олон жил байрласны эцэст тусгай байр олоход тусалж Болгарын ЭСЯ байсан байрыг өгөхийг хүссэн. Үүнийг нь дэмжсэн манай ГЯД-ны саналыг Улаанбаатар хотын гүйцэтгэх захиргааны болон эрх бүхий зарим албан тушаалтан үл хэрэгсэн тэр байшинг "хүүхдийн номын сан" болгоно гэлээ. Хүүхэд ордоггүй "номын сан" одоо ч байсаар л.

Энэ мэт хандлага элчин сайдаар ажиллаж байсан миний хувьд Францын талтай харилцааны асуудал ярилцахад хүнд байсныг хэлэхэд илүүдэхгүй. Францын социалистуудын засгийн газар Улаанбаатарт суугаа ЭСЯ-аа "санхүүгийн хүндрэлээс" шалтгаалж хаасан нь дээрх хандлагуудтай холбоогүй гэхийн аргагүй гэж боддог.

Бигэрийн Д. Түмэнжаргал, нарийн бичгийн дарга Я. Дашням нарын хамт Испанийн нийслэл Мадридад очив. Испанийн хаан Хуан Карлост 1979 оны 11 дүгээр сарын 29-нд итгэмжлэх жуух бичгээ барьсан. Ийнхүү Монгол Улсаас Испанид суух анхны элчин сайд болж билээ.

Гадаад улсын элчин сайдуудыг итгэмжлэх жуух бичгээ барихад гүйцэтгэдэг ёслол онцлогтой. Тэр нь уламжлал бололтой юм билээ. Тухайлбал, элчин сайдыг байрлаж байгаа өргөөнөөс нь ГЯД-ны ёслолын албаныхан машинаар ГЯД-ндаа хүргэж, тэндээс 4-8 морь хөлөсөн сүйх тэргэнд суулгаж хааны ордонд аваачдаг. Хаан болон албаны бусад хүмүүс нь ёслолын тусгай хувцастай, одон, хүндэтгэлийн тэмдгээ зүүдэг байна. Намайг итгэмжлэх жуух бичгээ барихад энэ ёс журмаа баримталсан.

Итгэмжлэх жуух бичгээ барьсан тухайг тэр орой орбитын навтруулгээр мэдээлсэн бөгөөд энэ ёслолтой холбогдсон өнгөт зуруудыг бидэнд өгсөн. Энэ бүхнийг түүхэн баримт гэж үздэг бололтой юм билээ.

Олон улсын хэлэлцээ, яриа, хамтын ажиллагааны нэг төв-ЮНЕСКО(Боловсрол, шинжлэх ухаан, соёлын олон улсын

байгууллага) бол НҮБ-ын төрөлжсөн байгууллагуудаас томоохонд нь ордог. ЮНЕСКО-гийн дэргэд суух Монгол Улсын байнгын төлөөлөгчөөр 5 жил гаруй (1978-1984) ажиллахаа түүний ээлжит ерөнхий бага хурал, гүйцэтгэх зөвлөлийн хурал болон ЮНЕСКО-гийн шугамаар болсон зарим хуралд оролцох завшаан надад тохиолдсон.

1978 онд гарын үсэг зурсан Монгол-ЮНЕСКО-гийн хамтын ажиллагааны тухай санаамж бичиг Монгол, ЮНЕСКО-гийн хамтын ажиллагааны гол чиглэлийг тодорхойлж байв. ЮНЕСКО-гийн үйл ажиллагааны программаар тодорхой хэд хэдэн ажлыг манай улс хэрэгжүүлсэн. Тухайлбал, хөгжлийн онолын үзэл баримтлалаар олон улсын эрдэмтдийн симпозиумыг 1980 онд Улаанбаатарт ЮНЕСКО-гийн ивээл дор хийлгэв. Улсуудын хөгжлийн байдал, хандлагын талаар эрдэмтэд санал дэвшүүлж байв.

Симпозиумын баримт бичиг англи хэл дээр хэвлэгдсэн. Харин баримт бичигт тусгагдсан санаа, тодорхой саналуудыг манай холбогдох байгууллага, эрдэмтэд цаашид судалж тухайн үед нь анхаарсан бол хэрэгцээ шаардлагатай зүйлүүд олон байсныг дурдъя. Түүнийг үзэл суртлын нэг туйлаас авч үзсэнээр орхигдсон гэж боддог. Манай эрдэмтэд, судлаачид капиталист биш хөгжлийн замын тухай онолоо батлан нотлох чиглэлээр түүнд оролцсоныг нуугаад нах вэ.

Төв Азийн түүхийн 10 боть ном хэвлүүлэхээр ЮНЕСКО-гийн программд орсон. Түүнд Монгол, Зөвлөлт, Хятад зэрэг хэд хэдэн улсын нэртэй томоохон эрдэмтэд оролцож зохих бүлгүүдийг бичиж эхэлсэн. Монголын түүхэнд холбогдох хэсгийг Ш. Бира, Ишжамц зэрэг манай эрдэмтэд бичсэн.

Программын хүрээнд манай түүх, соёлын дурсгалт газар-Хархорин, Амарбаясгалант хийдийг сэргээх асуудлыг судлах, ховор ном судрыг сэргээн засах, хадгалалт хамгаалалтыг орчин үеийн шинжлэх ухаан-техникийн ололтыг ашиглан сайжруулах, зарим дээд сургуулиудын материаллаг баазыг бэхжүүлэх, боловсролын салбарын зарим мэргэжилтнүүдийн мэргэшлийг дээшлүүлэх зэрэг асуудлыг хэрэгжүүлж түүнд ЮНЕСКО-гийн программаар тусламж авч байв.

Монгол улс ЮНЕСКО-гийн гишүүн болсон 20 жилд түүний гүйцэтгэх зөвлөл, нарийн бичгийн дарга нарын газарт өөрийн иргэдийг ажиллуулж байгаагүй юм.

Хэд хэдэн хүнийг судлаад орос, франц хэлтэй дипломач Т. Чимиддоржийг нарийн бичгийн дарга нарын газарт ажиллуулахаар ЮНЕСКО-д санал болгоход англи хэл эзэмшсэн байх шаардлагатай гэв. Иймээс ЮНЕСКО-гоос 12 мянган долларын цалин авч

Т. Чимиддоржийг Москвад дипломатын академид 2 жил суралцуулаад 1983 онд ЮНЕСКО-гийн нарийн бичгийн дарга нарын газарт ажиллуулсан билээ. Энэ асуудлаар ЮНЕСКО-гийн ерөнхий захирал, түүний орлогчидтой удаа дараа уулзаж ярилцах шаардлага гарч байсан. Ийнхүү Монгол улсын иргэн ЮНЕСКО-гийн НБДГ-г анх удаа ажиллав.

ЮНЕСКО-гийн гүйцэтгэх зөвлөл 51 гишүүнтэй. Ази, Номхон далайн бүс нутгийн улсууд 8 суудалтайгаас 1983 онд хугацаа нь дуусч буй 5 суудалд нэр дэвшүүлэх байв. Манай улс элчин сайд Бу. Дашцэрэнгийн нэрийг дэвшүүлэв. Нэр дэвшигчийг гишүүн улсуудад танилцуулах, сурталчлах, улс бүрийн байр суурийг судлах, дэмжлэг авахын тулд бололцоотой бүх арга хэлбэрээр ажиллав.

Дорнод Европ, Африк, Арабын групп манай нэр дэвшигчийг дэмжихээ илэрхийлсэн. Баруун Европ, Латин Америкийн группээс дэмжлэг авахад хүнд байсан. Тэр үед Монгол, Америкийн хооронд дипломат харилцаа тогтоогүй байсан ч кандидатураа дэмжүүлэх үүднээс Баруун Европын бүсийн группийг тэргүүлж байсан Америкийн байнгын төлөөлөгч элчин сайд хатагтай Жерартай уулзаж ярилцдаг байв.

Азийн групп хэд хэдэн удаа хуралдсан боловч тохиролцоонд хүрч чадаагүй. 5 суудалд 8 кандидатур дэвшиж ерөнхий бага хуралд орлоо. Сонгуулийн эхний шатанд Хятад, Япон, Бангладеш зэрэг дөрвөн улсын кандидатур олонхийн санал авч, Шри Ланка, Монгол хоёр тус бүр 86 санал авч тэнцэв. Бусад нь цөөн санал авсан учир хасагдав. Хоёрдахь шатны сонгуулийн өмнөх завсарлагын 10 минут тун удаан юм шиг бодогдож байж билээ. Хоёрдахь шатны сонгуулиар манайх олонхийн санал авч Монголын иргэн анх удаа ЮНЕСКО-гийн гүйцэтгэх зөвлөлд сонгогдсон нь энэ. Хоёрдахь шатны сонгуулийн шувтаргаар би хурлын байрнаас түр гарахаар явж байтал Пакистаны байнгын төлөөлөгч "Танайх ялсан, баяр хүргэе" гээд гар барьж байлаа. Завсарлагын хэдэн минутад хүчний харьцаа ийнхүү өөрчлөгдсөнийг харахад Монгол улс маань дэлхийн хамтын нийгэмлэгт зохих байр сууриа эзэлсэн юм байна даа гэж бодогдсон.

1983 оны Ерөнхий бага хурлын байгууллагуудын зарим тушаалд манай төлөөлөгчдөөс сонгогдсон. Үүнтэй холбоотой нэг тохиолдлыг дурдъя. Эмэгтэйчүүдийн асуудал хэлэлцэх комиссын орлогч дарын сонгуульд Азийн группээс нэр дэвшүүлэх болов. Тэр тушаалд Монголын төлөөлөгчийн гишүүн-ЮНЕСКО-гийн монголын үндэсний комиссын нарийн бичгийн дарга Н. Итгэлийг дэвшүүлэхээр би санал оруулав. Гэтэл нэг улсын төлөөлөгч энэ сонгуульд эмэгтэй хүнийг

дэвшүүлэх нь зүйтэй гэдэг юм байна. Бусад нь онцын ч юм хэлсэнгүй. Би дахин уг хэлэх зөвшөөрөл авч, манай төлөөлөгчид бичгийн дарга Н. Итгэл эмэгтэй хүн, ЮНЕСКО-гийн ерөнхий бага хуралд олон удаа оролцож байгаа юм гэв. Хуралд оролцогсод ингэлдэж билээ.

1977 онд Ташкентад Монгол улсын Ерөнхий консулын газрыг байгуулахтай холбогдсон ажлаар намын удирдлагын шийдвэрээр хэд хэдэн удаа очиж консулын газрыг нээх бэлтгэл ажлыг хангаж, Монгол улсын анхны консулын газрыг байгуулахад Узбекистаны ЗХУ задарч байсан ид үе-1990 онд Ташкентад суух Монгол улсын орж байсан Узбекистан, Казахстан, Киргизстан, Туркменистан улс дараа дараагаар тусгаар тогтнолоо тунхаглав. Монгол улс тэдгээрийг олон улсын эрх зүйн хэм хэмжээний дагуу хүлээн зөвшөөрч Дипломат харилцаа тогтоосон билээ.

Монгол улсын Засгийн газар Бүгд Найрамдах Узбекистан Улсыг хүлээн зөвшөөрч Дипломат харилцаа тогтооход бэлэн байгаагаа Махмудова Ш. Н-нд 1991 оны 9 дүгээр сарын 28-нд гардуулахад тэр хамгийн түрүүнд хүлээн зөвшөөрөх улсын нэг гэж бид үзэж байсан гэдгээ хэлж байв.

Шинэ тогтолцоонд шилжиж, тэдгээр улс шинэ тутам байгаа нь эхний үед хоёр талын харилцааны асуудлаар ярилцах, хэлэлцэхэд ямар нэг бэрхшээл тохиолдож байсан. Гэхдээ тэд Монгол улстай харилцаагаа хөгжүүлэх эрмэлзэлтэй байгаагаа илэрхийлж байсан юм.

Монгол улсын Гадаад харилцааны гадаад дахь байгууллагуудад 13 жил ажиллахдаа Дипломат төлөөлөгчийн газрын гурван төрөлд нь алба хашсанаа ийнхүү өгүүлэв.

ЭСЯ, олон улсын байгууллагын дэргэд суугаа төлөөлөгчийн газар, консулын газрын аль алины нь онцлогтой юм гэдгийг ямар нэгэн харилцаанд мэдэв. Эдгээр томилолт миний хувьд олон улсын энэ буюу.

Монгол улсын Гадаад харилцааны төв байгууллагад референтээс газрын дарга хүртэл 16 жил гаруй ажилласны ихэнхийг консулын албанд зүтгэсэн. Энэ албаны төвийн болон хилийн чанад дахь байгууллагад алба, амины асуудлаар гадаад, дотоодын иргэд,

байгууллага хандах нь өдөр тутмын зүйл. Урьдаас тааварлаж мэдэхэд хэцүү асуудал амьдралд нь тохиолдсоноос уурлаж бухимдсан, уйлж гомдсон, баярлаж хөөрсөн хүн олонтой дээ. Тэдэнтэй уулзан ярилцаж санаа бодлоо хуваалцахгүй өнгөрөөх эс суртахууны хэмжүүр консулын алба хашигчдад байхгүй. Улс хоорондын харилцааны асуудал ч консулын байгууллагын гадна байдаггүй. Консулын алба хүний төлөө зүтгэх алба.

1972 оны эхээр ГЯД-ны консулын хэлтсийг консулын газар болгох шийдвэр гарч, түүний анхны даргаар нь томилогдсон. Монгол улсын гадаад харилцаа өргөжиж байгаа нөхцөлд консулын албыг олон улсын эрх зүйн хэм хэмжээнд нийцүүлэн зохион байгуулах, өөрөөр хэлбэл консулын дүрэм, олон улсын гэрээ болон олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээний дагуу өөрийн улс, иргэд, хуулийн этгээдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах, бусад улстай найрсаг харилцаа хөгжүүлэхэд тус дөхөм үзүүлэх үүргийг нь хэрэгжүүлэх зохион байгууллагын арга хэмжээ авах шаардлагатайг ойлгосон.

Энэ үүднээс консулын салбарт бусад улстай гэрээ хэлэлцээр байгуулах, шинэчлэх, дотоодын хууль эрхийн актыг олон улсын эрх зүйн зарчим, заалттай нийцүүлэх, судалгаа, мэдээллийг зохих түвшинд хүргэх, бусад орны консулын байгууллагуудтай ажил хэргийн холбоо тогтоох, санал солилцох зэрэг нь уг албаны гол ажлын нэг байсан. Үүний тулд нэлээд зүйл хийснийг дурдахад илүүдэхгүй биз.

Монгол улсын гадаад паспорт, визийг шинэчлэх нь зарчмын ач холбогдолтой, зүй ёсны шаардлага байв. Юуны өмнө олон шат дамжлага, бичиг цаасанд зууралдсан чирэгдлийг арилгах, шуурхай болгоход консулын газрын хамт олон хүчин чармайлт гаргасан.

Яам, тусгай газар, аймаг, хотын ардын депутатуудын хурлын үйлдэгтэх захиргаад (тэр үеийн нэрээр)-тай нягт холбоотой ажилладаг болсон нь ашиг тустайгаа харуулсан.

Консулын албанд ажиллах боловсон хүчнээ бэлтгэх, дадлага нэрэгжил олгох нь энэ албаны ажлын нэн чухал хэсэг гэдгийг мартаагүй. Яамны удирдлага энэ бүхнийг ойлгон тусалж дэмжиж байсныг тэмдэглэв.

1970-аад оны дунд үеэс консулын албыг сурталчлахаар "Ардын төр" сэтгүүлд хэд хэдэн өгүүлэл нийтлүүлсэн, мөн "консулын албанд холбогдох баримт бичгийн эмхтгэл" жил бүр хэвлэгдэж байв.

Консулын албаны үйл ажиллагааг шуурхай, боловсронгуй болгоход орчин үеийн техник нэвтрүүлэх зайлшгүй шаардлагатай бөгөөд 1980-аад оны сүүлчээр компьютер, хэрэглээ

Ингээд л гүйцэх нь тэр. Сонирхоогүй, бүр төсөөгүй ажилд санаа, зоригсоо гадуур шилждэг байж. Намын даалгавар ийм байдаг хэмээн ухамсартаа шингээсэн юм чинь яах вэ. Хожим нь юм үзэж нүд тайлж явахад аль ч нам заримдаа ингэж л тулгадаг учрыг төсөөлсөн.

1963 оны 7 дугаар сарын 17-нд ийнхүү миний намтарт зүүдлээ ч үгүй шинэ хуудас хүчээр орж ирсэн юм. Дипломатын алба нарийн мэргэжил шаарддаг бөгөөд мэдэж хиймээр, мэдэхгүй байтлаа бас хийж болдог алба бололтой юм. Намайг томилохдоо Гадаад явдлын Яаманд дуулгаагүй аж. АНУ-ын Ерөнхийлөгч Франклин Рузвельт 1933 онд Чикаго-гийн их сургуулийн түүхийн профессор Уильям Доддыг зөвхөн өөртэй нь угсаар яриад Германд элчин сайдаар томилсонтой төстэй ч юм шиг санагдаж билээ. Германд фашист засаглал тогтсон эздрээтэй үед хүнээ АНУ-ын Ерөнхийлөгч яаж олох нь миний авсан томилолтоос ялгаатай байлгүй яах вэ.

Сайд М. Дүгэрсүрэн намайг элчин сайдын зангиа залахаар анх уулзахад "дээрээс ирсэн танд зааж зөвлөх юм байхгүй, өөрөө л мэдээд ажиллана биз" гэсэн нь мөн ч хатуухан хариуцлага тулгасан удирдамж байлаа. Албан тушаал өндөржих тусам их юм мэдэж чадах, үгүй бол хожим хогийн саванд орж, ёроолд нь наалдах ийм хоёрхон алхам байдгийг лавшуулан ухаарч авлаа. Мэргэжлийн хүнээс дутуугүй мэдэх, чадааг сайчуудад хүрч чадах ёстой болсноо сайдын үгнээс мартамгүй мэдрэх шиг болсон. Хий гэснийг хийх нэг хэрэг, хил давж ертөнцийн хэмжээнд ажиллах өөр агуулга.

Гадаад харилцаа түүхэндээ мэргэжлийн хоёрхон сайдаар (С. Аварзэд, М. Дүгэрсүрэн) удирдуулсан юм. Мэргэжлээр удирдах, сургаар ажиллах хоёрын ялгаа асар ихийг монголын дипломатууд андахгүй. Мэргэжилтнээр хангагдсан яаманд М. Дүгэрсүрэн шиг мэргэжил чадвартай, хатуу шаардлагатай, хүний мөс чанар төгөлдөр боловсон хүчин бишгүй л байгаа. Ганцхан тэр бүрийг дээрээ сайн мэддэггүйн гачлан байдаг биз.

Маргааш явах болоод уулзахад Цэдэнбал "бид чинь халбагаа дүрээтэй нь аягатай цайгаа уудаг улс шүү дээ. Дипломатууд, ер нь соёлтой хүн ингэдэггүй, дипломат хүнд жижиг юм байх ёсгүй байх шүү" гэж энгийн хүүрнэсэн яриа олон асуултын хариу болсон гэлтэй. Ж. Самбуу гуай манай зарим дипломатын цамцны ханцуй чанасан ходоод шиг байдаг гэгчхээд тамхиа сороод өөр юу ч хэлээгүй, хожим нь ажиглаж явахад ийм ханцуй мөн олон тааралдаж байсан шүү. Мэргэдийн тэмдэглэлийг сар уншаад Европ руу дипломат албанд мордсон доо.

Москвад Монголыг давхар хамаарч байсан Румыны элчин сайд

Н. Гүене Элчин сайдын Яамаа үзүүлсэн нь надад шинэ яам байгуулах олон бодол төрүүлж байв. Энэ нь үнэт мод, гантиг чулуугаар уран барилга учрасан асар том харш аж. Зөвхөн хүнсний зоорь нь 6 вагоны багтаамжтай гээд бод л доо. Зургийн үзэсгэлэнд нь Нидерланд, Испани, Италийн сонгодог зураачдын бүтээл тавиагатай байв. Дипломат мэргэжил наанадаж дэлхийн сонгодог бүтээлүүдийг таньдаг, бүр ч мэддэг байхыг шаарддаг юм. Энэ талаар ч гэсэн дипломатуудтай ярилцах чадвартай байхгүй бол Чингисийн Монголыг төлөөлөх битгий хэл ХХ зууны сэхээтэн байхад чамлагдана. Гүене хүндата өргөхдөө намайг Чингисийн Монголын анхны байнгын элчин сайд гэсэн юм. Энэ үг нэг янзын сорилт гэж бодоод хариу үгэндээ би зөвхөн Чингисийн Монголыг төдийгүй шинэ Монголын элч болж замд гарлаа гэж хэлсэн юм. Нэг жилийн өмнө Чингисийн 800 жилийн ойг тэмдэглэж дэлхийгээр нэг шуугиулсан, дараахан нь Д. Төмөр-Очирыг Чингисийн ой тэмдэглүүлсэн буруутан болгож зарласан энэ хоёр үзүүрийн аль талд нь шинэ элчин сайд байна вэ? гэж сорьж сонжих нь зүйн хэрэг биз. Улс төрчид үнэ хүрэх дүгнэлтийн үндэс болж мэднэ.

Зүүн Европын жижигхэн Париж гэгддэг Бухарест манай улсынхаас арай олон хүн амтай, бие даасан бодлого явуулдаг улсын нийслэлээ. Улаанбаатар, Бухарестийн хооронд улс төр, үзэл суртлын зөрөө байснаас ч юм уу 10 хонож хүлээж байж элчин сайд болдог юм байна. Энэ хооронд олон элчин сайд нарыг өөр хотод үйлдвэр үзүүлнэ гэж Румыны ГЯД урихад нь оролцохоос татгалзлаа. Итгэмжлэх жуух бичгээ төрийн тэргүүнд бариагүй байж дипломат үйл ажиллагаанд оролцох нь тохиромжгүй гэж үзсэнийг минь хожим Румыны дипломатууд таашааж байснаа хэлж билээ. Бухарестэд 60 гаруй орны байнгын дипломат төлөөлөгчийн газар байсны дээр монголынх шинээр нэмэгдэж, бидний гурван дипломат тэвдүүхэн боловч нэг л хүн шиг ажиллаж байлаа. Унтах ор, унах машингүй, лей болгосон хэдэн төгрөгтэй ийм л хэдэн монгол дороо л танил олонтой, талын чинээ болох нь тэр. Дэлхий 2-3 ертөнц болж хуваагдсан боловч дипломат корпус гэх тэрүүхэндээ аминч, үзсэн дуулснаа дотроо шүүн, фрилцаж, хамтран ажилладаг жижигхэн "ертөнц" байдаг юм. Нийлэхгүй, дэлдэг хүн ч байдаг, үзэл сурталдаа яг баригдаад мэндгүй зөрдөг дипломат ч байх л юм билээ. Бид тэгж өөрийгөө тусгаарлаагүйн үр дүнгээ "талын чинээ" хэмээн томьёолсон ухаантай юм. Мэдээлэл сайтай гэж нэр хүнд олсны учир энэ буюу. АНУ-ын Ерөнхийлөгч Жон Кеннеди алагдсан үед Элчин сайдын Яаманд нь очиж гашуудал ихэрхийлсэн чинь эндээс нэг орлогч сайд сүрхий бангадаж билээ. Цэг үеэ гэж...

Хөгжлийн ойролцоо түвшинд яваа, адилхан шинэ зам бэдэрсэн, хоёр жижиг улс гэж их л хөдий болсон Албаний элчин сайдад бараалхнаа. Мэндийн дараа тэр (Рапи) та нар Хрущевын уриханд орсон ревизионистууд гээд яриагаа эхэлдэг юм байна. Тантай үзэл суртлаар маргах гэж би ирээгүй. Танай улсыг, таныг хүндэтгэж ирсэн гээд л учирлаж үзсэн чинь хэрүүл өдөөд болдоггүй шүү. Таныхаар бол та бидний төлөөлж буй хоёр улс Сталины урхинд уясан дэгээний хоёр үзүүрт өлгөөтэй байсан болох нь ээ. Та нар шараа, бид айргаа ууж, хэний ч аманд орохгүйн төлөө гээд хундага өргөчихсөн чинь мань хүн ууж орхилоо. Ингэж хундага шарз бидний улс төр, үзэл суртлын маргааныг товчилсонсон.

Хөгжингүй том улсын дэмгүйгээр бага жижиг орон хоцрогдлыг давсан туух байхгүй. Зарим орон тусгаар тогтнолоо алдаж "хоол" болсон нь олоон. Дэлхий нэг л улс, орон гэр байх ёстой гэж бичигдсэн, бичигдээгүй онол, баримтлал хоёр манга гаруй жил үргэлжилж, суулчийнх нь 1992 оны 5 дугаар сард М. Горбачевын гаргасан дэлхийн Засгийн газар байгуулах санал болж байх шиг байна. XIX зуунаас дэлхийн коммунизмын тухай яриа үүсч, XX зуунд дэлхийн хувьсгалын төлөө гээд монголчууд хүртэл таваргаж байлаа. Цаана нь дэлхийн капитализмын төлөө хүч ач тач үзэлцэж байсныг би ярих нь илүүц юм. 1930 оноос эхлээд манай удирдагчид хойд хөрштэйгээ нийлэх санал тавьж байсан нь дэлхий нэг улс болох юм гэсэн хийсвэрлэлээс улбаатай ч байж болзошгүй. Гэндэн, Чойбалсан, Цэдэнбал нараас дараа дараалан тавьсан саналыг дэлхийд нэртэй Грек, Монгол мэтийг ямар ч улс өөртөө нэгтгэж болохгүй гээд Сталин хүлээж аваагүйг моголов ярьж байна хэмээн миний найз С. Аварзэд, Моголов хоёр сайд байхдаа хэлдэг байж билээ. Энэ бол Аварзэд, Моголов хоёр муудалцаагүй, сүрхий дотно байсан цаг л даа. Албаний элчин сайдын хэлсэн шиг урхинд орсон, урхидаад барьчихсан нь үгүй гэдгийн нэгэн баримт мөн биз. Нийлэх гэсэн санал нэг туйлшрал. Харин Оросыг түшсэн тулдаа манай улс тусгаар тогтнон, хоцрогдлоос гарч хөгжил дэвшлийн замд орсон юм. Ингээгүй бол Балба, Бутан, Сикким зэрэг тус тивийн бөглүү орны хэмжээнд үлдэх буюу бүр нэр үсгүй болсон байхыг үгүй гэх газаргүй. Ингээд эрэгцүүлэн бодож, элдвийн юм уншиж байхад дал илүү жил алдаж, олон хойш урагшаа хаагайж, олон удирдагчийн нүүр үзсэн энэ эриний Монголд Х. Чойбалсан, Ю. Цэдэнбал хоёр л жинхэнэ улс төрийн удирдах зүтгэлтэн (лидер) байсан гэмээр санагдана.

Японы элчин сайд Сугамицутай ойр дотно танилцаад нэлээд удлаа. Манай үндэсний барын амралтын өдөр утга ж. маргааш нь

надад зоог барих юм боллоо. Дипломат харилцаагүй гэж цаарлалсангүй, төвөөс зөвшөөрөл ч эрсэнгүй. Хоёр Элчин сайдын Яамны найман хүн үйлчлэгч ч хэрэглэлгүй нэгэн оройг хамт өнгөрүүлээ. Манай улсыг Нэгдсэн Үндэстний Байгууллагад элсэхэд дэмжсэн санал өгч Монгол улсыг хүлээн зөвшөөрснөө Япон улс албан ёсоор илэрхийлсэн юм. Гэтэл танайхан ойлгоогүй бололтой, одоо хүртэл дараачийн алхам хийх санаачилга Монголын Засгийн газраас гарсангүй гэж тэд хэллээ. Би төвд ирж удирдлагадаа гайгүй сайн тайлбарласан, тэгээд ч юм уу хоёр орны хооронд дипломат харилцаа тогтоох явдал хөдөлгөөнд орж эхлэх шиг болсон. Хожим нь судалж байхад газар газар байгаа дипломатуудаас Японтой хамгийн дотно харилцдаг нь би байсан болж, Японы Засгийн газар ярилцах газар, хүнээ ийнхүү сонгосон байж билээ.

Нэг мэдэхэд Италийн "Унита" сонин сурвалжлагчтай танил болчихсон байх юм. Түүгээр дамжуулан Италийн нэг хөрөнгөтөн Малбази (хачин нэр шүү)-тай танилцаа. Монголд үнээний ферм, гахайн завод бариад өгье, оронд нь юу өгсний чинь авна гэлээ. Румынд байгуулсныг нь үзлээ. Үнэхээр өндөр ашиг орлоготой аж ахуй, хямд ч байсан. Төвдөө тавьсаар зөвшөөрүүлж 3 хүн ирүүлснийг Цэдэнбал, Самбуу нар хүлээн аваад л мөн ч их дэмжсэндээ. Бүтсэнсэн бол мах, сүүний өнөөгийн гацлан алта болохгүй гэхэд багасах байсан нь лавтай. Төлөвлөгөөний комисс хөрөнгөтнөөс нь айсан юм уу, өндөр авсан гэж шаралхсан ч юм уу "манж" үгээр моголдоод хойш нь тавьчихсан Цаадуул нь ажил хэрэгч улс болохоор жаал хүлээгээд цөхөрсөн. Зуучилсан надад суудлын "Фиа" машин бэлэглэснийг Элчин сайдын Яам арваад жил эдлээд жолоочдоо худалдсан гэнэ лээ. Малбази гуай хожим нь бэлэглэсэн машиныг элчин сайд голоод яамныхаа хашаанд хаячихаад явжээ гэж ярьж явсан байна билээ. Гэндэн ингэж машин голдог баян болсон ухатай.

Румын орон газар зүйн байршил сайн, эрдэс, түүхий эдийн баялагтай, хөдөө аж ахуй хөгжсөн, хүн ам олон гэх мэт давуу талтай боловч Европын хоцронгүй орны нэг байв. 1960-аад оноос Молдавыг буцаан авах, капиталист ертөнцийн тэргүүний техник, технологид тулгуурлан улс орноо үсрэнгүй (бар болох маягийн) хөгжүүлэх бодлого удирдлагын түвшинд, мөн тэргүүлэх хэсгийн дунд дэвсгэргийнх бололоо. Н. Чаушеску 1965 онд засгийн эрх авснаар Молдавыг өөртөө нэгтгэхээс бусад мөрөөдөл 15 жилд бараг биелэв. Ард түмэн хүчит нударган дор хөлсөө дуслуулан цаггүй эргэжээ. Тэргүүний технологи нэвтэрсэн ч гэсэн бүтээгдэхүүн нь

Дэлхийн зах зээлд өрсөлдөж дийлсэнтгүй. Зах зээл уламжлалаа дагахаас бус, шинэ гарч ирсэн орны таваар руу хошуураад дайрдаг гэнэн хонгор биш ажээ. Дэлхийн хөгжлийн банк, валютын сангаас зээлдсэн 14 тэрбум долларын өр төлөхийн тулд эдийн засгийн хэмнэлтийн онцгой бодлогыг улс орондоо тулгаж орхисон чинь гүнзгий хямрал болоод багатзүүрджээ. Аж ахуйг буруу хөтөлбөл үр дагавар түмэн нь өлсч ядрахын туйлд хүрчээ. 1989 онд үржсэн хүүтэй нь 21 тэрбум долларын өр төлж дууссан боловч өлссөн ард түмэн босч Чаушескуг тэргийтэй нь хамт өчигтүй буудаж, хурсан уур хилэнгээ мэдүүлж тэтгэвэрт гарсансан бол дэлхийд ховорхон үнэ хүндтэй хүн байх байсан юм даа. Албан тушаалд шунахын уршиг ийм байдаг хойно яана гэх вэ. Хоол хүнсний гачаал хүн амын уур хилэнг туйлд нь хүртэл бадрааж, улмаар улс төрийн тэмцэл бослогод хүргэдэг нь баттай үнэн юм. Би 1984 онд Румынд хоёр дахиа очсоноос эхлэн энд өгч, бослогын үед Элчин сайдын Ямаа, монгол иргэдээ яаж хамгаалахаа төлөвлөж байсан юм. Удирдлага, олон түмэн хоёрын дунд зааг гарч, зөрчил гүнзгийрсэн үед хурц тэмцлээс өөр зам байв гэж үү. Миний энэ ярьж байгаа маань ядуу улс биш, нэг хүнд 2700 долларын үндэсний орлого оногддог чадалтай орны жишээ юм. Хоол хүнсгүйдээ ард түмэн нь өлсөөгүй, байснаа ерөнд өгөөд өөрсдөө өлбөрч байжээ. Энэ орон хүнсний карт бий болгож хуарангийн дэглэмд ороогүй нь сонин. Картын систем бол дайны үед хэрэглэдэг захиргаадалтын эдийн засгийн ядарсан арга, залхуучуудыг өөлшүүлдэг зэрэг муу юм олныг араасаа дагуулж явдаг жамтай.

XX зууны хоёрдугаар хагасын Румыны хямрал Чаушескугийн төмөр гартай холбоотой. 1964 оноос хойш удаа дараа уулзаж, заримдаа тус дэм авч, 50 насны нь ойгоор дилкорпусын ахлагчийн хувьд баяр хүргэж, дундынхаа бэлгийг гардуулж байсан удаатай. Улаанбаатарт циркийн барилга баруулах санаатай хэдэн жил хөөцөлдөөд мухардахад өөрийнхөө Соёлын Яам, бүр давраад Улс төрийн Товчоо үзэл суртлын шалтгааны улмаас татгалзсаны цааха гарч Чаушескуд манайх элс, ус хоёроос өөр материал гаргаж чадахгүй хэмээн хэлж байгаад л бүтээсэн, түргэн, сайн ч барьж өгсөн.

Социализмын орнуудад дэлхийд тэргүүлэх технологи байхгүй гэж 1965 онд Чаушеску зарлаад гол гол үйлдвэрээ АНУ, Англи, Франц, Холбооны Германы машин техникээр тоноглосон, энэ ч зөв байлаа. Түүхий эд, эрчим хүчний нөөцөөсөө хамаагүй давсан том том

үйлдвэр, бүтээгдэхүүнээ дэлхийн зах зээлийнхээс хямд худалдах чадваргүй энэ хоёроос болоод улс орныг дуужлгуурийн шонгийн дор авчсан юм. Сайн технологийг зөв ашиглаж чадахгүй бол баян айлын бүтэцгүй хүүтэй адил болдог бололтой. 1985 онд Чаушеску олон улсын банк, валютын сангийн тусламж бол хөгжиж буй орныг тамирдуулан сүйрүүлэгч мөн болохыг манай ард түмэн, Ази, Африк, Латин Америкийн нэгэн адил яс махаараа мэдэргээ. Мөлжлөгийн мөн чанар энэ байна гээд л авч гарсан. Хорин жилд нэг хүний хоёр мэдэгдэл иймэрхүү байв.

1968 онд таван орны цэрэг Чехословакт орсон үед Чаушескутэй уулзахад тэрээр Дубчикийн урилгаар хэдхэн хоногийн өмнө тэнд байсан, хувьсгалын эсэргүү байгаагүй. Гэтэл өнөөдөр Зөвлөлт улс тэрмийлгэн эзлээд байна гэсэн. Хариуд нь би та коммунист учраас эсэргүү танд харагдаагүй байлгүй гээд хэлчихсэн чинь муухан ишлэж билээ.

Олон улсын нэг хурал дээр Сирийн төлөөлөгч Румыны дорлогын улс төрийн бодлогыг шүүмжилсэн учир хилэнгэж, шөнийн цатт Чаушеску элчин сайд нарыг дуудаж улсынхаа удирдлагад өнөө шөнө мэдэгдэж манай дотоод хэрэгт оролцохоо зогсоо гэсэн шаардлагыг Сирид маргааш өгсөн байхыг тулгаж билээ. Ийм бүдүүлэг зогшин Румынд тус болоогүй.

Боловсролгүй энэ хүнийг хар ухаан, зориг хоёр нь авч явсан юм. Ойр байгаа хүмүүс нь ер бусын авьяас билэгтэн, ард түмний хайрт эцэг, бүх нийт таныг маш нягт тойрон хүрээлсэн гэж өөрт нь итгүүлсээр, бас олон түмнийг ятаж шүүтүүлэх явуулга их хийсэн нь Чаушеску өөрийгөө онцгой хүн, бүхнийг мэддэг, чадал ид шидтэн, мэдэшгүй дархан эзэн гээд бүр мах цусандаа хүртэл итгэчихсэн юм. Ард түмнээс ямар их холдон тасарч хөндийрснөө огт мэддэггүй байсан, амь алдахдаа ч ухаараагүй байх аа. Нэг үзэл суртал дангаар өөрчлөж плюрализмыг үгүйсгээд байвал хэзээ нэгтээ сүйрдэг бололтой.

Би 1964 оны эхээр Румынд хоёрдахиа томилогдож 21 жилийн өмнө өөрийн ажлыг авсан Лувсанравдангаас элчин сайдын алба авах ээлж тэмцэсэн юм. Нас ахисан намайг дипломат албаныхан маргасангүй. 16 жилийн дараа дахин авч, дассан газар минь илгээн 5 жил гаруй эмгэгтүүлсэнд сэтгэл оргилуун байдаг юм. Бодвол урт наслах бэлтгэлгүй. Нэг хүнийг хоёр дахин нэг оронд элчин сайдаар суулгах нь үнэ цээр л доо. Манай орны хувьд надаас өөр хүнд тохиолдоогүй ч болов уу. Эргээд очиход таних хүн олон, зарим нь дэвшсэн, зарим нь зогсон, дилкорпусынхаас гэхэд нарийн бичгийн дарга байсан хүн

дайттай тэжээх алт мөнгөн. Румын Москвадтай зөрдөг гээд л хойш тавьсан байх, бид хохирсон хэвээр.

Миний танил Грекийн наймаачин арьс ширний өөдөс арван вагоныг авья, хоёр сая доллар бэлнээр өгөв гэж 1987-1988 онд их л туйсан, манай гадаад худалдааныхан баяр хүргээд хойш нь тавьж чимээгүй болсон. Израилийн бизнесмен нарны эрчим хүч ашиглах авсаархан төхөөрөмж арвыг Говьд тавьж туршъя, нэгийг нь бэлэглээ гээд туйж байсан. Би ч Израил гэж зэнзийлээгүй, хөдөө аж ахуй, гадаад харилцааны удирдлагад 1988-1989 онд тавьж л орхисон. Цөлийг ашиглахдаа Израил үнэхээр туршлагатай гэж хэн хүнгүй мэддэг байх аа.

Хүнд төрөлхийн шинж чанар байдаг, тэр нь насан турш бэхждэг, харин өөрчлөгдөх нь ховор гэж мэргэд зөндөө бичсэн байдаг. Энэ жороор бол би өөрийгөө ил тод байх мөрөөдөлтэй, бас ч өөрчилж шинэчлэх тал нь дийлсэн хүн юм болов уу гэж оноогоод байгаа. Үнэнд хавьтах эсэхийг таних нөхөд тайлах биз. Гадаад харилцааны Намны хамт олон намайг гадны хүн, юм мэдэхгүй гэх байдал хэзээ ч гаргаагүй хамт олны хуучин гишүүний ёсоор дэмжиж байсанд тун их баяртай байдаг. Миний үр ач нар ч үүнийг ер мартахгүй гэдэгт эргэлзэх юун. Нэгдтэй хамт Элчин сайдын Яам байгуулсан туйлын ажилсаг, чин шударга, эршүүд сайн нөхөр эвсэг сайхан хамтран зүтгэгч дипломат Ч. Даваасүрэн зан мэдэхгүй догшин хүлгийн нуруун дээр тогтоож өгсөн найз минь билээ. Арван жилд турван яамны нэрээр очсон янз бүрийн мэргэжлийн хүмүүс бүгд л намайг дэмжиж ил тод, гашуун насуун үгийг минь дааж, эх орны үүрэг даалгаврыг нэр төртэй биелүүлж байсан юм. Зарим газар, бидний дунд ч гэсэн ёс суртахууны доголдол гардаг байсан л даа. Дээд газраасаа, хамт олноосоо нуугаад өнөрчих зуршил аяндаа бий болж тэр нь бие биенээ матах, ажилд нөлөөлөх, хэн нэгний мууг үзэхэд ч хүрдэг байж. Миний хувьд юуг ч удирдлагаасаа, хамт олноосоо нууж байсангүй. Тусгай өндөр хангамж авч, хилийн гадна суугаа хэн ч гэсэн өөрийн иргэний адил эрх эдэлж, илүү үүрэг биелүүлэх ёстой гэсэн зарчим барьдаг байлаа. Зугаа цэнгэл хөөцөлдөхийг тэвчиж байсангүй. Улс амьтны дунд улайм цайм хэлүүлэх хэдий үнэн ч гэсэн эвгүй л дээ. Хойно хоцрох хор уршил нь бага, ил тодын ид шид нь их юм. Ил тод байна гэдэг уг чанартаа үнэнч шударгын хэмжүүр биз. Хилийн цаана ажиллах хүн үнэнч шударга байх нь эх оронч байхтай тэнцэнэ. Шударга биш хандлагата бүр итгэл хүлээх боломжийг үгүй хийж байдаг юм. Улс төлөөлнө гэдэг дээд газрын заавар, жороор хийдэг ажил биш. Мэдлэг ухаанаар бие даан явуулдаг улс төрийн бодлого юм. Чаддаг хүн олж тавих нь дээд эзний үүрэг, чадахгүй бол хохирох нь улс биш, улс төлөөлөгч өөрөө

байдаг жамтай.

Румын бол Францтай ёс заншил, соёлын уламжлалт харилцаатай, хүн амын олонхи нь францаар ярьдаг, францчуудыг "эгч" гэж хүндэлдэг ард түмэн. Францын ерөнхийлөгч генерал Шарль Де Голь Чаушескугийн урилгаар 1967 онд Румынд айлчилсан юм. Чаушеску Оросыг зад шүүмжилж байсан үе. Де Голлийг дээд зэргээр хүндэллээ. Хоёр орныхоо харилцааг гаруун сайн магтав. Де Голь хоёр ч удаагийн яриандаа хүнд үед нь Румынд Франц тусалж байсан. Францыг санахдаа нар гарах зүгийнхээ хөршийг мартаж болохгүй, тэр чинь байгаагүй бол 25 жилийн өмнө та нар ч, Европ ч, дэлхий ч хүрэн тахлын идэш болон сөнөх л байсан. Оросуугээр Европ бие даан тогтоход бэрх гэж хэлсэн юм. Маргааш нь 100 мянган хүн цуглуулж Чаушеску нар гарах зүгийн хөршийнхөө тухай хамгийн сайн сайхан үгийг амьдралдаа анх удаа, мөн сүүлчийн удаа хэлсэн билээ. Оросууд бүр өнгөрсөн хойно Де Голлийг цагт нь ойлгоогүйгээ хүлээсэн байдаг.

Горбачев 1987 онд Румынд айлчлахдаа ард түмний нь ядуу зүдүү байдлыг ойлгуулах санаатай танай ард түмний амьдрал доогуур байна гэж хэлэхэд нь Чаушеску тийм ээ, гэхдээ танай хүн амын туравны жороос нь манай ард түмэн дээр амьдардаг шүү гэж хариулсан гэдэг.

Чаушеску өглөө 7 цагт шинэ барилга байгууламжийн явцыг үзэж, 10 цагт сайд нараа цуглуулан хуралдуулаад 14 цагт хөдөө тариан тарибай дээр ажиллаж, 18 цагт албан тасалгаандаа гадаадын төлөөлөгчид хүлээн авах жишээтэй л ажиллаж байхыг нь олон яарсан. Төр толгойлно гэдэг амь бие хайрлахгүй зүтгэхийг шаарддаг юм. Улс орны мөнгөн санг бусад нөөцийн хамт ганцхан Чаушеску эгнээнэ. Сайд, ерөнхий сайд ч улаан мөнгөний мэдэлгүй байв. Үрэлсэн байдлыг ингээд л таг хааж чадсан юм. Гэтэл өөрөө олон ордой, тэнд хичнээн олон хүн цалин аваад, эзэн жилдээ ганц ч гэсэн ирж итгэлгүй хүлээгээд мөнгө урсаж байдгийг бодоход өөрийгөө хүнээс бус анд хорвоогийн дээдэд, бурханаас өндөрт залсных биз ээ. Албан тушаал, өрөгмжлөл, хүнийг хүн биш "чөтгөр-зэглэр", "шулам" юу ч болгон хувиргахыг тааж хэлэхэд бэрхээ. Гэхдээ ард түмнээ өлөн шүүн, зовлонтой байлгаваас өршөөл үздэггүй нь бичигдээгүй хууль байх магадгүй.

Чаушеску Румыны хөгжил дэвшилд нөлөөлсөн томохон зүтгэлтэй байв. Гэхдээ хүчээр дайрч зорьсноо биелүүлдэг хүн. Улс орныг таагүйгээр үлдсэн нь үлэмж, хэзээ нэгтээ сэргэж, Румын хамттан болж, бүх юм өөрт нь бий.

Дипломатч байсан арван жилээ эргэн харахад оромдож байсангүй, осолдож эндсэн нь ч бага. Баяжиж хөлжих гэж шунасангүй. Зусардаж зулгаа элээсэнгүй, дарсан ч дардаггүй, булсан ч бултайх ажигтай, сурлагын дэвтэр өвөртлөөгүй хэр нь сураар боолгох сул амьтан байсангүй. Дипломатчийн зиндаанд нүүрээ улайлгаагүй авсандаа бардам байна. Эздийнхээ чихийг халууцуулж үзсэнгүй, харин ч санаачилгатай, мэдээлэл сайтай, шуурхай ажигладаг, үүрэг даалгаврыг цагт нь гүйцэд биелүүлдэг, зорьсондоо хурдэг гэсэн үнэлэлт дүгнэлтийг хүртэж ирсэн минь гадаад харилцаанаас надад өгсөн шагнал юм. Насны наран баруунаа хэвийж, цагаан үс хуучирсны тэмдэг болсон цаг үед нэгэн удаа өөрийнхөө тухай дагд байсан зүйлийг ил гаргаад тэмдэглэсэн нь энэ буюу. Дахиад би өөрөө ч, өөр хүн миний тухай бичихгүй биз.

П.Дармаа
Түшээ

ДУРСАМЖ ЯРИА

Гадаад харилцааны яамны ажилтан Р.Янжмаа ахмад Дипломатч П.Дармаатай уулзаж дурсамж яриаг нь тэмдэглэсэн юм.

Р.Янжмаа: Та хэдэн оноос Дипломат алба хашиж эхэлсэн бэ?

П.Дармаа: Би ЗХУ-д (хуучин нэрээр) Дорно дахины судлалын Институтийн тусгай тасатг сурагцаж, 1941 онд дүүргэж ирээд Сайд нарын Зөвлөлийн орлогч дарга байсан ч, Сүрэнжавын нарийн бичгийн даргаар томилогдон 6 сар ажиллаж байтал түүнийг МАХН-ын Төв Хорооны нарийн бичгийн даргаар томилж оронд нь Сангийн Яаманд нэгдүгээр орлогч сайдаар ажиллаж байсан С.Лувсанг томиллоо. Ингээд С.Лувсантай цуг ажиллаад 6 сар болж байтал буюу 1942 оны намрын үеэр нэг өдөр Лувсан гуай намайг ерөөндөө дуудаж "Чамайг наадмын үеэр нэг өдөр Лувсан гуай намайг ерөөндөө дуудаж "Чамайг албан ажлын шаардлагаар ГЯЯ-ны Өрнөд хэлтэст ажиллуулахаар болсон, чи наадмаас хойш тийшээ оч" гэдэг юм байна. Ингээд ГЯЯ-ны Өрнөд хэлтсийн даргаар томилогдов оо. ГЯЯ гол төлөв виз паспортын л асуудал хариуцдаг, бодлогын чанартай асуудлыг ерөнхий сайд л шүүхэд байлаа. Юу сайндаа 1945 онд АНУ-ын дэд ерөнхийлөгч бүрхтэсийг манай улсад ирэхийг бид мэдэхгүй, нэг л өдөр дагалдаж дээд тал, хүмүүсийг нь хооллуулах даалгавар аван түүнийг биелүүлэх даан явуу, гинаж байх вэ дээ.

Эзний үүрэг, онд намайг очиход ГЯЯ Долоохон орон тоотой, засгийн газарт

Зорног эзэлдэг байлаа. Маршал Чойбалсан ерөнхий сайд бөгөөд ГЯЯ-ны сайд байлаа. Намын Төв Хороонд зөвлөх Приходов, бас засгийн зөвлөх Цапкин гээд ажиллаж байлаа шүү дээ. ГЯЯ гэдэг маань шүүдэн, нууц, шифр, аж ахуй, виз, паспортын л ажил эрхэлдэг байлаа. Манай Өрнөд хэлтэс гэж юу байх вэ дээ, ганц л би Бүх юм хариуцна, түүний эрхлэгч, Дипломат шуудан, гэрээ эрх, виз, паспорт гээд л... Асуулт: Гэрээ эрх гэж бүх гэрээ хэлэлцээрийг хариуцан боловсруулж байгуулдаг байсан хэрэг үү?

Хариулт: Үгүй, үгүй. Нэг авдарт 1921 оноос хойш байгуулсан гэрээ хэлэлцээрийг данслаг дагалдахыг хэлж байгаа юм. Өөрөөр хэлбэл түүний эрхлэгч, түүнээс биш бид түүнийг байгуулдаггүй байсан юм. Мөн Түвдтэй байгуулсан гэрээ бас байдаг байлаа.

Асуулт: Өрнөд хэлтэс маань чухам юу хийж байв аа?

Хариулт: Хоёрдугаар дайны үед ЗХУ-д явуулах бэлгийн зүйлийг оруулах, дайны явцын тухай ард олонд ухуулан таниулах л үүрэгтэй байсан. Бас фронтод бэлэг хүргэхээр явах хүмүүсийн паспортыг бичиж, ЗХУ-ын ЭСЯ-нд биеэрээ хүргэн өгч виз авдаг маш их ажилтай байлаа.

Асуулт: ЗХУ-ын тухай судалгаа хийж, харилцаа хөгжүүлэх талаар санал дэвшүүлж байв уу?

Хариулт: Тийм судалгаа мудалгаа гэж байгаагүй. Гол нь ЗХУ-ын төлөөлөгч байлаа шүү дээ. Манайх ч мөн адил представитель (төлөөлөгч)-тэй байсан юм. Гэхдээ гол асуудлыг Төв Хороо, маршал боловсруулдаг, тэд л шийдвэрлэдэг байлаа.

Асуулт: Бичиг хэргээаж зохион байгуулж байсан юм бэ?

Хариулт: Бичгийн эхийг бид боловсруулаад Намсрай сайдаа оруулж, Тэгээд цохилтаад маршалд өгнө.

Асуулт: Ямар хэлээр бичиг баримтаа үйлддэг байсан бэ?

Хариулт: Монголоороо бичнэ. Харин маршалын дэргэд Аюузана гэдэг сүрхий сайн орчуулагч байсан юм. Авгай нь Цэрмаа гэдэг юм. Одоо өөд болчихсон байх аа. Аюузана бүх бичиг баримтыг оруулж, нөгөө зөвлөх, сургагчид танилцуулдаг байсан байх.

Асуулт: 1921 онд ГЯЯ шинээр байгуулагдахдаа 20-иод орон байсан байсан юм байна лээ. Тэгэхлээр яагаад 1940-өөд онд тийм олон тоотой байсан юм бол?

Хариулт: Тийм ээ, тэр үед нэлээн том сүрхий яам байсан юм байсан. Яагаад сүүлд нь тийм их цөөлснийг мэдэхгүй. Хэрэгцээ бага болж л дээ.

Асуулт: Ингээд таныг 1942 онд ГЯЯ-нд ирэхэд Дипломат ажилтан байсан гэж 4 хүн байсан байх нь ээ.